



**“МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ КЛИРИНГИЙН ТӨВ” ХХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

20 20 оны 11 сарын 10 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Г

Г

Журам батлах тухай

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2, Сангийн яамны 2020 оны 11-р сарын 10-ны өдрийн 8-1/7115 тоот удирдамж, “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК-ийн Дүрмийн 7.4.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 11-р сарын 10-ны өдрийн 06-р хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

Нэг. “Мөнгөн хөрөнгийн гүйлгээний түр журам”-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Батлагдсан журмыг Санхүүгийн зохицуулах хорооноос батламжилсан өдрөөс эхлэн үйл ажиллагаандaa мөрдөн ажиллахыг Гүйцэтгэх захирал О.Эрдэнэгэрэлд зөвшөөрсүгэй.





“Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК-ийн ТУЗ-ийн
2020 оны 11-р сарын 10-ны өдрийн 24 тоот тогтолцын хавсралт

МОНГӨН ХӨРӨНГИЙН ГҮЙЛГЭЭНИЙ ТҮР ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК (цаашид Клирингийн төв)-ийн гишүүн бус үнэт цаасны компанийд хамаарах тооцоо, мөнгөн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэхүү харилцаанд Монгол Улсын Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, СЗХ-ны “Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчийг танъж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам”, Монгол банкны “Төлбөрийн системийн оролцогч хоорондын их дүнтэй төлбөр тооцооны журам”, “Төлбөрийн системийн хоорондын бага дүнтэй төлбөр тооцооны журам” болон энэхүү журмыг удирдлага болгоно.

1.3 Мөнгөн хөрөнгийн гүйлгээг клирингийн үйл ажиллагаа эрхэлсэн алба хариуцан гүйцэтгэнэ.

1.4 Энэхүү журам нь клирингийн гишүүнчлэлгүй үнэт цаасны компаниуд дараа төлбөрт клирингийн үйл ажиллагаанд шилжих хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Хоёр. Журмын нэр томъёо

2.1 Энэ журамд орсон дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно. Үүнд:

2.1.1 “анхан шатны баримт” гэж данснаас мөнгө хүссэн өргөдөл, мөнгөн хөрөнгийн орлогын баримтуудыг;

2.1.2 “мөнгөн хөрөнгийн баланс” гэж дансууд дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь өмнөх өдрийн үлдэгдэл дээр тухайн өдрийн орлогыг нэмж, зарлагыг хасч гаргасан үлдэгдэлтэй тэнцэх дүнг;

2.1.3 “их дүнтэй гүйлгээ” гэж Монгол банкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан хязгаартай тэнцүү буюу түүнээс дээш үнийн дүнтэй банк хоорондын гүйлгээг;

2.1.4 “бага дүнтэй гүйлгээ” гэж Монгол банкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан хязгаартай тэнцүү буюу түүнээс доош үнийн дүнтэй банк хоорондын гүйлгээг;

2.1.5 “орлогын гүйлгээ” гэж Арилжааны банкнаас Клирингийн төвийн данс руу хийсэн гүйлгээг;

2.1.6 “зарлагын гүйлгээ” гэж Клирингийн төвийн данснаас Арилжааны банк руу хийсэн гүйлгээг;

2.1.7 “харилцагчийн данс” гэж Клирингийн төв дахь харилцагчийн дансыг;

2.1.8 “шимтгэл” гэж арилжааны үнийн дүнгээс тодорхой хувиар тооцсон дунг;

2.1.9 “хураамж” гэж банк хоорондын гүйлгээний үйлчилгээний хөлсийг;

2.1.10 “ҮЦК” гэж Санхүүгийн зохицуулах хорооноос зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан үнэт цаасны компанийг;

Гурав. Мөнгөн хөрөнгийн гүйлгээнд тавигдах шаардлагууд



3.1 Клирингийн төвөөр дамжуулан харилцагчийн дансанд хийгдэх мөнгөн хөрөнгийн гүйлгээ нь бэлэн бус хэлбэртэй байна.

3.2 Клирингийн төв мөнгөн хөрөнгийн гүйлгээний анхан шатны баримтын хүчинчлийн тодорхой, хүлээн авч, баримтын бүрдлийг програмын мэдээлэлтэй тулган шалгаж гүйлгээг хийнэ.

3.3 Мөнгөн хөрөнгийн гүйлгээний анхан шатны баримтын үзүүлэлтүүд тодорхой, гаргацтай, бүрэн гүйцэд бөглөсөн, засваргүй, тамга тэмдэгээр баталгаажиж, данс эзэмшигчийн цахим үнэмлэхний хуулбарыг хавсаргасан байна.

3.4 Данс эзэмшигчийг төлөөлөн өөр этгээд гүйлгээ хийлгэх тохиолдолд Иргэний хуулийн 64.2-т заасан шаардлагыг хангасан итгэмжлэлийг үндэслэн төлөөлөгч этгээд анхан шатны баримтанд гарын үсэг зурж баталгаажуулна.

3.5 Зарлагын гүйлгээг зөвхөн данс эзэмшигчийн нэр дээрх арилжааны банкны дансанд шилжүүлнэ.

3.6 Мөнгөн хөрөнгийн гүйлгээний анхан шалтны баримтын бүрдэл дутуу эсвэл буруу тохиолдолд Клирингийн төвийн гүйлгээ хариуцсан ажилтан тухайн баримтыг хүлээн авахаас татгалзана.

3.7 Мөнгөн хөрөнгийн анхан шатны баримтыг шалган хүлээн авсан гүйлгээ хариуцсан ажилтан энэ тухай холбогдох баримтад тэмдэглэн гарын үсэг зурна.

Дөрөв. Мөнгөн хөрөнгийн гүйлгээ

4.1 Клирингийн бус үнэт цаасны компанийд хамаарах мөнгөн хөрөнгийн гүйлгээнд арилжааны банкнаас Клирингийн төвийн дансанд хийгдэх орлогын гүйлгээ, Клирингийн төвийн данснаас арилжааны банк руу хийгдэх зарлагын гүйлгээ багтана.

4.2 Клирингийн төвийн мөнгөн хөрөнгийн гүйлгээ ажлын өдөр бүр 09:00 цагт эхэлнэ.

4.3 Мөнгөн хөрөнгийн их дүнтэй зарлагын гүйлгээг 09:10 цагаас 16:20 цагт, бага дүнтэй зарлагын гүйлгээг 09:10 цагаас 17:00 цагийн хооронд гүйцэтгэнэ.

4.4 Орлогын гүйлгээг гүйлгээний ажилтан анхан шатны баримтын бүрдлийг шалгасны үндсэн дээр гүйцэтгэж, ахлах ажилтан хяналт тавина.

4.5 Орлогын гүйлгээний хувьд тухайн төрлийн гүйлгээний дансны дугаар, дансны нэр, УЦК-ийн нэр зэрэг мэдээллийг тодорхой бичсэн байх шаардлагатай бөгөөд эдгээр мэдээлэл банкны хуулганы тайлбарт бичигдээгүй эсвэл нэр данс зөрсөн, тухайн данс нээгдээгүй зөргээс дансанд байршуулах боломжгүй бол “нэр данс тодорхойгүй” дансанд бүртгэнэ.

4.6 Нэр данс тодорхойгүй дансанд бүртгэгдсэн орлогыг харилцагчийн хүсэлтээр буцаах зарлагын гүйлгээ хийнэ.

4.7 Төв банк болон бусад харилцагч банкны хуулгыг үндэслэн Монгол банкан дахь харилцах дансны нэгдсэн балансыг өдөр бүр хөтөлнө. Улирлын эцэст дансны үлдэгдлийн баталгаа гаргаж, төв банк баталгаажуулна.

4.8 Мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг хийхдээ анхан шатны баримт (Хавсралт 1, Маягт-1)-ыг УЦК-иудаас хүлээн авч компанийн мэдээллийн сан дахь мэдээлэлтэй тулган, харилцагчийн данснаас хасалт хийж, зарлагын гүйлгээг гүйцэтгэнэ. Үүнд:



МОНГОЛЫН ВУУЧЛАГЫН КЛИРИНГИЙН ТӨВ

ХХК

80200-018

4.8.1 Гадаад харилцагч мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг хийлгэхдээ Монгол улсын “Цахим гарын үсгийн тухай” хууль болон уг журмын холбогдох маягтын шаардлага хангасан анхан шатны баримтыг бүрдүүлж, ~~вуючлагчны~~ УЦК-д хүргүүлнэ.

4.8.2 Энэ журмын 4.8.1 дэх заалтын дагуу ирүүлсэн анхан ~~шатны~~ баримтыг тухайн УЦК-ийн холбогдох эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажуулна.

4.8.3 Энэ журмын 4.8.1 ба 4.8.2-т заасан шаардлага хангасан анхан шатны баримтыг үндэслэн гүйлгээний ажилтан харилцагчийн мөнгөн хөрөнгийг зөвхөн тухайн харилцагчийн арилжааны банк дахь дансанд шилжүүлнэ.

4.9 Зарлагын гүйлгээг Клирингийн үйл ажиллагаа эрхэлсэн албаны захирал эсвэл ахлах ажилтан хянан баталгаажуулна.

4.10 Дараах тохиолдолд Клирингийн төв дахь харилцагчийн данс хооронд мөнгөн хөрөнгө шилжүүлнэ. Үүнд:

4.10.1 СЗХ-ны Улсын байцаагчийн актыг үндэслэн;

4.10.2 компанийн дотоод албадуудаас ирүүлсэн албан бичгийг үндэслэн;

4.10.3 Шүүхийн шийдвэрийн дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн шүүхийн шийдвэр болон албан бичгийг үндэслэн мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг харилцагчийн данснаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд;

4.11 Клирингийн төв мөнгөн хөрөнгийн гүйлгээний баримтын бүрдэл дутуу, сэжиг бүхий тохиолдол болон тусгаарлалтад байгааг шалгах зэрэг үндэслэлээр тухайн гүйлгээнд нэг өдрийн турш хориг тавих эрхтэй бөгөөд гүйлгээнд хориг тавьж байгаагаа холбогдох УЦК болон харилцагчид тухайн өдөртөө багтаан мэдэгдэнэ.

4.12 Монголбанкны банк хоорондын их дүнтэй төлбөр тооцооны журмын дагуу харилцах данснаас гүйлгээ хийгдсэн тохиолдолд гүйлгээ буцахгүй.

4.13 Гүйлгээний ажилтан сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийхээс өмнө тухай бүр Дотоод хяналтын ажилтанд мэдээлнэ.

4.14 Гүйлгээний ажилтан мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийх явцад систем дээр ямарваа нэгэн saat алба болон Дотоод хяналтын ажилтанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй:

Тав. Мөнгөн хөрөнгийн гүйлгээнд хориглох зүйлс

5.1 Клирингийн төвийн ажилтнуудад дараах зүйлийг хориглоно. Үүнд:

5.1.1 баримтын бүрдэл дутуу, мэдээллийн сантай баримтын мэдээлэл зөрсөн, зохих зөвшөөрөлгүй гүйлгээ хийх, баримтыг хуурамчаар бүрдүүлэх, нуун дарагдуулах;

5.1.2 холбогдох УЦК-аар баталгаажаагүй, тамга тэмдэггүй, гарын үсэггүй баримтаар гүйлгээ хийх, тодорхой шалтгаангүйгээр орлогын гүйлгээг буцаах;

5.1.3 факс болон и-мэйл, скайнардан ирсэн анхан шатны баримтаар гүйлгээ хийх; (энэ заалт гадаад харилцагчийн хувьд хамаарахгүй)

5.1.4 мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг харилцагчаас бусад этгээдийн банк дахь харилцах дансанд шилжүүлэх (энэ заалт насанд хүрээгүй хүүхдийн дансанд хамаарахгүй);



- 5.1.5 зарлагын гүйлгээг гаргахдаа итгэмжлэгдсэн төлөөлөгчийн харилцах дансанд шилжүүлэх;
- 5.1.6 аж ахуйн нэгжийн данснаас хувь хүний харилцах дансуу зарлагын гүйлгээ гаргах болон хувь хүний данс хоорондын шилжүүлэг хийх;

Зургаа. Шимтгэл хураамж

- 6.1 Шимтгэл, хураамжийг энэ журмын 2-р хавсралтын дагуу тооцно.
- 6.2 Арилжаа эрхлэх байгууллагаар хийгдсэн үнэт цаасны арилжааны хэлцэл нь СЗХ-ны тогтоол болон шүүхийн шийдвэрээр буцах тохиолдолд өмнө тооцогдсон шимтгэлийг үнэт цаасны зах зээлд оролцогч байгууллагуудаас суутгах үүргийг Клирингийн төв хүлээхгүй.
- 6.3 Банк хоорондын гүйлгээний хураамжийг харилцагчийн данснаас гүйлгээ хийх тутамд тооцож авна.

Долоо. Тайлан мэдээ

- 7.1 Клирингийн төв нь 3-р хавсралтад заасан дараах тайлан мэдээг өдөр бүр гаргана.
- Үүнд:

- 7.1.1 Мөнгөн хөрөнгийн орлогын тайлан (Маягт 2)
- 7.1.2 Мөнгөн хөрөнгийн зарлагын тайлан (Маягт 3)
- 7.1.3 Мөнгөн хөрөнгийн гүйлгээний хураангуй мэдээ (Маягт 4)
- 7.1.4 Мөнгөн хөрөнгийн баланс (Маягт 5)
- 7.1.5 Харилцах дансны орлого зарлагын баланс (Маягт 6-1)
- 7.1.6 Харилцах дансны бага дүн ороогүй орлого зарлагын баланс (Маягт 6-2)
- 7.1.7 Буцаагдсан орлогын жагсаалт (Маягт 7)
- 7.1.8 Харилцах дансуудын үлдэгдэл (Маягт 8-1)
- 7.1.9 Харилцах дансуудын бага дүн ороогүй үлдэгдэл (Маягт 8-2)

7.2 Клирингийн төв шимтгэл, хураамжийн мэдээг сар, улирал бүр гаргана.

Найм. Баримтын хадгалалт, нууцлалт

- 8.1 Мөнгөн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой анхан шатны баримт, мэдээ мэдээллийн хадгалалт, нууцлалыг холбогдох журмын дагуу тухайн ажилтан хариуцна
- 8.2 Мөнгөн хөрөнгийн гүйлгээний баримтыг тухай бүр хавтаслаж, дугаарлан, цоож, лацтай сейф, шүүгээнд хадгалах бөгөөд архивлах хэмжээнд хүрмэгц архивт шилжүүлнэ.

Ес. Хариуцлага

- 9.1 Энэ журмыг зөрчсөн тохиолдолд Компанийн дотоод журамд заасан сахилгын шийтгэл ногдуулна.
- 9.2 Мөнгөн хөрөнгийн орлогын гүйлгээнд банкны буруутай үйлдлээс шалтгаалан гарах аливаа хохирлыг Клирингийн төв хариуцахгүй.
- 9.3 Анхан шатны баримтын бүрдэл, мэдээллийн үнэн зөв байдлыг баримт ирүүлсэн УЦК бүрэн хариуцна.

Хавсралт 1

ДАНСНААС МӨНГӨ ХҮССЭН ӨРГӨДӨЛ



1. *Харилцагчийн дансны дугаар
2. *Харилцагчийн овог нэр
3. *Регистрийн дугаар
4. Оршин суугаа хаяг
5. Харилцах утасны дугаар

Хувьцааны мөнгө, Бондын мөнгө (доогуур зурах) ----- төгрөг
мөнгийг (үсгээр) ----- (байгууллага, хүний нэр) -----
*банк дахь ----- * тоот дансанд олгоно уу.

Өргөдөл гаргасан----- (.....)
(гарын үсэг) /харилцагчийн нэр/

Харилцагчийг төлөөлсөн: итгэмжлэгч өөрөө

Хүлээн авсан: УЦК-ийн ажилтан: ----- (.....)

Хянасан: УЦК-ийн Гүйцэтгэх захирал: ----- (.....)

(Тамга)

20 оны сарын өдөр

Өргөдлийг шалган хүлээн авч,

Гүйлгээг хийсэн: гүйлгээний ажилтан ----- (.....)

Хянасан: ахлах ажилтан ----- (.....)

(Тэмдэг)

20 оны сарын өдөр

Мэдэгдэл:

*заалтыг заавал бөглөх бөгөөд буруу бөглөсөн тохиолдолд гүйлгээ хийгдэхгүй болохыг анхаарна уу. Тухайн харилцагч нь харилцах банкны нэр, дансны дугаараа буруу бичсэнээс гарах хариуцлагыг Клирингийн төв хариуцахгүй.

Хавсралт 2

ШИМТГЭЛ ХУРААМЖ



Шимтгэл хураамжийн төрөл	Шимтгэл хураамжийн хувь хэмжээ
Хувьцааны арилжаа (хоёрдогч зах зээл)-ны шимтгэл	Арилжаанд оролцогч тал тус бүрээс 0.24 хувь
Компанийн бондын арилжаа (хоёрдогч зах зээл)-ны шимтгэл	Арилжаанд оролцогч тал тус бүрээс 0.0075 хувь
Засгийн газрын бондын арилжаа (хоёрдогч зах зээл)-ны шимтгэл	Худалдсан талаас 0.00175 хувь, Худалдан авсан талаас 0.00375 хувь
Банк хоорондын гүйлгээний хураамж	Гүйлгээ тутамд 500 төг

Хавсралт 3



Мөнгөн хөрөнгийн орлогын тайлан

д/д	Данс	Тоо хэмжээ	Хүлээн авагч банк	Гүйлгээний утга

Нийт дүн

Тайлан гаргасан: ажилтан / /

Тайлан хянасан: ахлах ажилтан / /

Majgat -3

Мөнгөн хөрөнгийн зарлагын нэгдсэн тайлан

огноо

д/д	Овог нэр	ҮЦК-ны код	Дансны дугаар	Шилжүүлгээр	Тайлбар

Нийт дүн:

Тайлан гаргасан: ажилтан / /

Тайлан хянасан: ахлах ажилтан / /

Majgat -4

Мөнгөн хөрөнгийн гүйлгээний хураангуй мэдээ

огноо

Д/Д	ҮЦК-ны нэр	Орлогод				Зарлага	
		тоо		үнэ	тоо	үнэ	
	Нийт дүн						

Тайлан гаргасан: ажилтан / /

Тайлан хянасан: ахлах ажилтан / /



Мөнгөн хоронгийн баланс

ҮЦК-ийн код	ҮЦК-ийн нэр	Орлого	Зарлага

Дүн

Дүн

Харилцагчийн дансны нийт үлдэгдэл

Эхний үлдэгдэл.....

Орлого.....

Зарлага.....

Эцсийн үлдэгдэл.....

Нийт үлдэгдэл.....

Баланс

Данснуудын үлдэгдэл

Арилжааны шимтгэлийн данс

Нийт

Харилцагчийн мөнгөний үлдэгдэл

Дүн

Тайлан гаргасан: ажилтан

Тайлан хянасан: ахлах ажилтан



**Харилцах дансны орлого, зарлагын
гүйлгээний баланс (Амжилттай, Амжилтгүй)**

Тайлангийн огноо:

Хэвлэсэн огноо: 0000/00/00 00:00:00

Эхний үлдэгдэл: 00,000,000,000.00

Амжилттай

Д/д	Огноо	Дансны дугаар	Орлого	Зарлага	Гүйлгээний утга	Тайлбар
		Нийт				

Амжилтгүй

Д/д	Огноо	Дансны дугаар	Орлого	Зарлага	Гүйлгээний утга	Тайлбар
		Нийт				

Эцсийн үлдэгдэл: 00,000,000,000.00

Тайлан гаргасан: ажилтан

/ /

Тайлан хянасан: ахлах ажилтан

/ /



МОНГОЛЫН
ҮНЭТ ЦААСНЫ
КЛИГИНГИЙН ТӨВ
ХХК
90200-0109
ХТУ4426 Ⓛ 6051804

**Харилцах дансны орлого, зарлагын
гүйлгээний баланс (Амжилттай, Амжилтгүй)
(Бага дүнтэй гүйлгээ ороогүй)**

Тайлангийн огноо:

Хэвлэсэн огноо: 0000/00/00 00:00:00

Эхний үлдэгдэл: 00,000,000,000.00

Амжилттай

Д/д	Огноо	Дансны дугаар	Орлого	Зарлага	Гүйлгээний утга	Тайлбар

Нийт

Амжилтгүй

Д/д	Огноо	Дансны дугаар	Орлого	Зарлага	Гүйлгээний утга	Тайлбар

Нийт

Эцсийн үлдэгдэл: 00,000,000,000.00

Тайлан гаргасан: ажилтан

/ /

Тайлан хянасан: ахлах ажилтан

/ /



БУЦААГДСАН ОРЛОГЫН ЖАГСААЛТ

Огноо	ТХД	ҮЦК-Данс	ХА Банк	ХА Данс	Гүйлгээний дүн	Валют	Орлогын утга	Тайлбар

Тайлан гаргасан: ажилтан

/ /

Тайлан хянасан: ахлах ажилтан

/ /

ХАРИЛЦАХ БАНКУУДЫН ДАНСНЫ УЛДЭГДЛЭЭ

 Тайлангийн оноо: 					
Хэвлэсэн огноо: Монгол Төгрөг					
№	Банкны нэр	Дансны дугаар	Ийнчийн нийтийн дугаар	Орлого	Хувцасаж буй орлого

Хувцасаж буй зарлаг

Монгол Төгрөг

№	Банкны нэр	Дансны дугаар	Хувцасаж буй зарлаг

Шалгадаагүй зарлага

Харилцах хоорондын гүйлгүү

Орлого

Зарлаг

Мэдээ гаргасан: /

Мэдээ хянсан: /

ХАРИЛЦАХ БАНКУУДЫН ДАНСНЫ УЛДЭЭЛДЭЛДААНЧАЛАР ХОТ
(Бага дүнтэй гүйлгээ ороогүй)

Хэвлэсэн огноо:
Монгол Төгрөг

Тайлангийн огноо:
ҮНЭТ ЦААСНЫ
КЛИРИНГИЙН ТӨВ
ХХК

№	Банкны нэр	Дансны дугаар	Эхний мэдээлэлийн нийтийн ялангуяа	Орлогого	Хүчээгдэж буй орлогого	Зарлагын хувь

Хүчээгдэж буй зарлага

Монгол Төгрөг

№	Банкны нэр	Дансны дугаар	Хүчээгдэж буй зарлага

Шалтгаалагч зарлага

Харилцах хоорондын гүйлгээ

Орлогого

Зарлага

Мэдээ гаргасан:

Мэдээг хянасан: